МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 19 өдөр Дугаар А/155 Улаанбаатар хот

Хавдар судлалын үндэсний төвийн
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавдар судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлсугай.

2. Батлагдсан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв /Ж.Чинбүрэн/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 400 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД А.ЦОГЦЭЦЭГ

080505

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 19-ны өдрийн
А/155 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хавдар судлалын үндэсний төв (цаашид Төв гэх) нь Монгол Улсын хэмжээнд хавдар судлалын чиглэлээр лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, тухайн чиглэлээр улсын хэмжээнд бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг мөн.

1.2.Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.3.Төвийн оноосон нэр нь “Хавдар судлалын үндэсний төв” байх ба товчилсон нэр нь “ХСҮТ”, оршин байгаа газар нь Монгол Улс, Улаанбаатар хот 210648, Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, Нам Янжуугийн гудамж гэсэн хаягтай байна.

1.4.Төвийн нэрийг англи хэлээр “National Cancer Center” гэж орчуулна.

1.5.Энэ дүрмийн зорилго нь төвийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тодорхойлж, удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тогтоон хяналт тавих, эд хөрөнгийн эрх, түүнээс үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино. Энэхүү дүрэм нь Төвийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, санхүүжилттэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

1.6.Төв нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, санхүүгийн харилцах данс, өөрийн бэлэгдэлтэй байна.

1.7.Энэ дүрмийн 1.6-д заасан тамга, тэмдгээр төвийн албан ёсны шийдвэр, албан, гэрээ, хэлцлийг тамга тэмдгээр баталгаажуулна. Төвийн ерөнхий захирлын томилсон албан тушаалтан тамга, тэмдгийг түшнэ.

Хоёр. Төвийн үндсэн зорилго, түүний эрх, үүрэг

2.1.Төвийн эрхэм зорилго хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч байхад оршино.

2.2.Төвийн зорилго нь Монгол улсын хүн амыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилох, эмчлэх, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, зөвлөх, гүйцэтгэлийг хянах, тайлагнахад оршино.

2.3.Төвийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь хавдартай тэмцэх ажлыг өмчийн хэлбэрээс үл хамааран эрүүл мэндийн бүх шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, нийт хүн амын нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан явуулахад оршино.

2.4.Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.4.1.Үйлчлүүлэгчийг дээдлэх,

2.4.2.Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах,

2.4.3.Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих,

2.4.4.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах,

2.4.5.Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах,

2.4.6.Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах,

2.4.7.Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах,

2.4.8.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх.

2.5.Төвийн эрх

2.5.1.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэл зүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

2.5.2.Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, материаллаг болон хүний нөөц, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах,

2.5.3.Ижил чиг үүрэг бүхий гадаадын эмнэлэг, төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн хавдрын тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох,

2.5.4.Судалгаа, шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах,

2.5.5.Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах,

2.5.6.Тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх,

2.5.7.Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх,

2.5.8.Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

2.6.Төвийн үүрэг

2.6.1.Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд хавдрын төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах,

2.6.2.Дараах чиглэлээр үндэсний хэмжээнд хавдрын төрөлжсөн мэргэжлийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх: тархи, мэдрэлийнхээс бусад бүх байрлалын хавдрын мэс засал, хавдрын туяа, хими болон хөнгөвчлөх эмчилгээ, хавдрын эс болон эд зүй судлал, хавдрын бүртгэл мэдээлэл,

2.6.3.Эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй хавдрын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх,

2.6.4.Хавдрын тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, арга хэмжээний санал боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах,

2.6.5.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах,

2.6.6.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх,

2.6.7.Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх,

2.6.8.Хавдрын чиглэлээр үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх,

2.6.9.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр олон нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, холбогдох байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах,

2.6.10.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр хүн амын өвчлөлийн түвшин, тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлэх, төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах,

2.6.11.Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх,

2.6.12.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр эмнэл зүйн судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох,

2.6.13.Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх,

2.6.14.Үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах,

2.6.15.Тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал гомдолд дүн шинжилгээ хийж залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах,

2.6.16.Үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр олон улсын түвшний итгэмжлэл авсан байх,

2.6.17.Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил болон эдийн засгийн хувьд үр ашигтайг нь сонгон хэрэгжүүлдэг байх,

2.6.18.Өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулж хэрэгжүүлэх,

2.6.19.Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах,

2.6.20.Ажиллагсдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах,

2.6.21.Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Гурав. Төвийн удирдлага, түүний эрх, үүрэг

3.1.Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал, дэд захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.

3.2.Төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхийг Ерөнхий захирал хэрэгжүүлж, тушаал гаргана.

3.3.Төвийн дэд захирал өөрийн хариуцсан чиг үүргийг Ерөнхий захирлын удирдлага дор гүйцэтгэж, тайлагнана.

3.4.Удирдлагын зөвлөл нь байгууллагын хөгжил, зохион байгуулалт, өдөр тутмын удирдлагын үйл ажиллагааны асуудлаар Ерөнхий захиралд зөвлөх чиг

үүргийг гүйцэтгэнэ. Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий захирлын тушаалаар батална.

3.5.Удирдлагын зөвлөл нь төлөвлөгөөт болон шуурхай хэлбэрээр хуралдаж, олонхийн саналаар хурлын шийдвэр гаргана.

3.6.Төвийн эрдэм шинжилгээ судалгаа, эрүүл мэндийн технологийн үнэлгээ хийх, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд үнэлгээ дүгнэлт өгөх, зөвлөх эрх бүхий Эрдмийн зөвлөл ажиллуулж болно. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрт нийцүүлэн Ерөнхий захирлын тушаалаар батална.

3.7.Төвийн Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл нь хурлын тогтоол, шийдвэр гаргана.

3.8.Төв нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, эмийн эмчилгээг зохицуулах хороо, бусад шаардлагатай хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулна.

3.9.Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь тасаг, алба байна. Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн удирдлага нь тухайн тасаг, албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажилтантай хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

3.10.Ерөнхий захирлын эрх, үүрэг:

3.10.1.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй байгуулсан Хөдөлмөрийн болон Үр дүнгийн гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулж, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө ажлаа хариуцан тайлагнах;

3.10.2.Төвийн хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн тасаг, албадын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

3.10.3.Тасаг, албадын хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоох, дэд захирал болон ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас халах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох, цуцлах;

3.10.4.Ажилтныг гадаад, дотоодод томилолтоор ажиллуулах, захиргааны чөлөө олгох, ажлын үр дүнг үндэслэн шагнаж, урамшуулах, хариуцлага хүлээлгэх;

3.10.5.Төвийн хэмжээнд мөрдөх журам, заавар, тушаалыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх;

3.10.6.Төвийг гадаад, дотоодод бүрэн хэмжээгээр төлөөлөх;

3.10.7.Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үр дүнгийн гэрээ байгуулан биелэлтийг ханган ажиллах, төсөв хөрөнгийг үр дүнтэй, зориулалтын дагуу захиран зарцуулах;

3.10.8.Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

3.10.9.Ажилтны талаар гаргасан өргөдөл, гомдлыг дангаараа буюу холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран шийдвэрлэх;

3.10.10.Ерөнхий захирал шаардлагатай тохиолдолд өөрийн эрх, үүргийг итгэмжлэлийн үндсэн дээр холбогдох албан тушаалтанд түр шилжүүлэх. Ийнхүү эрхээ шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй;

3.10.11.Төвийн бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, байгууллагын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дотоод аудиторыг томилон ажиллуулах.

3.11.Эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирлын чиг үүрэг

3.11.1.Төвийн захирлын тушаалаар батлагдсан өөрийн ажлын байрны чиг үүргийг гүйцэтгэх ба ерөнхий захирлын эзгүйд орлон ажиллах;

3.11.2.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний асуудлыг хариуцан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан оношилгоо, эмчилгээ, тусламж, үйлчилгээний журам, заавар, стандартыг төвийн хэмжээнд мөрдүүлэх;

3.11.3.Төвийн яаралтай тусламжийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн алсын дуудлага, зөвлөх баг ажиллуулах ажлыг удирдан зохион байгуулах;

3.11.4.Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, алсын зайн сургалт, зөвлөгөөг удирдан зохион байгуулах;

3.11.5.Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх ажлыг удирдан зохион байгуулах;

3.11.6.Зөвлөх эмч, эмч, тасгийн эрхлэгч, сувилагч нарын өдөр тутмын эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой асуудлыг зохицуулах, ажил үүргийн хуваарийг батлуулан ажиллах;

3.11.7.Төвийн хэмжээнд оношилгоо, эмчилгээнд олон улсын жишигт нийцэхүйц, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах;

3.12. Бодлого төлөвлөлт, хөгжил эрхэлсэн дэд захирлын чиг үүрэг

3.12.1.Байгууллагын болон хүний нөөцийн хөгжил, бодлого, төлөвлөлт, эрүүл мэндийн даатгал, төсөв санхүүжилт, бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.2.Төвийн төсөв санхүүжилт, нягтлан бодох бүртгэл, болон бусад санхүүгийн асуудлыг Ерөнхий захиралд тухай бүр танилцуулан, шийдвэрлүүлэх;

3.12.3.Эрүүл мэндийн даатгал, санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, санхүүгийн сахилга батыг сахиулах, батлагдсан төсвийн дагуу хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

3.12.4.Үйлчилгээний төлбөр, эрүүл мэндийн даатгалтай холбоотой иргэдийн санал гомдлыг шуурхай шийдвэрлэж, “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.12.5.Эрүүл мэндийн салбарын бодлого, хөтөлбөртэй нийцүүлэн байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах;

3.12.6.Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.7.Эрдэм шинжилгээ, судалгаа болон гадаад хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрийг салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжүүлэх, улсын хэмжээний эрт илрүүлгийн тусламж үйлчилгээ, сургалтыг удирдан зохион байгуулах;

3.12.8.Эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай хангамж, үйлчилгээ, технологийн нөхцлийг бүрдүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.9.Байгууллагын цахим технологийг салбарын мэдээллийн технологийн бодлого хөтөлбөртэй уялдуулан хөгжүүлэх асуудлыг удирдан зохион байгуулах;

3.12.10.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.11.Ажиллагсдын ажиллах нөхцөл, үйлчилгээгээр хангах, төсвийн санхүүжилтийг аль болох хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, зарцуулах, хангамж, үйлчилгээний ажлыг удирдан зохион байгуулах;

3.12.12.Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавьж, ажиллах;

3.12.13.Байгууллагын халдварын сэргийлэлт, хяналт, эрүүл ахуйн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.12.14.Байгууллагын үйлчилгээний соёлыг сайжруулах, захиргаа, хангамж үйлчилгээний ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

3.12.15. Төвийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг удирдан хэрэгжүүлэх.

Дөрөв. Гадаад, дотоод хамтын ажиллагаа

4.1.Төвийн Ерөнхий захирлын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар шийдвэрлэнэ.

4.2.Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

4.3.Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

Тав. Төвийн хавдар судлалын төрөлжсөн мэргэшлээр улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээ



Зургаа. Санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт

6.1.Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

6.1.1.Улсын төсөв;
6.1.2.Эрүүл мэндийн даатгал;
6.1.3.Үндсэн үйл ажиллагааны орлого /төлбөртэй тусламж, үйлчилгээ/;
6.1.4.Туслах үйл ажиллагааны орлого;
6.1.6.Гадаадын зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
6.1.7.Бусад эх үүсвэр

6.2.Төв нь санхүүжилт, эд хөрөнгийг төвийн үндсэн зорилго, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулж, ашиглана.

6.3.Төв нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө олж авах, тэдгээрийг данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

6.4.Төвийн эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.

6.5.Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэнэ.

6.6.Төв нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

Долоо. Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний ерөнхий чиг үүрэг

7.1.Чанар, дотоод хяналтын алба

Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, эрсдэлийн удирдлага, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавина. Төвийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулна.

7.2.Хавдрын мэс заслын клиник

Хавдрын мэс заслын клиникт ерөнхий мэс заслын тасаг, хагалгааны хэсэг, элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг, толгой хүзүүний мэс заслын тасаг, цээжний хөндийн мэс заслын тасаг, эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг хамаарна. Мэс заслын клиник нь тархи, мэдрэлээс бусад хорт хавдрын оношилгоо, эмчилгээ болон мэс заслын явцын бэлэн байдлыг хангаж, мэс заслын дараах согогийн нөхөн сэргээх эмчилгээний чиглэлээр улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Мэс заслын тасгууд нь тухайн чиглэлийн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг нэгдмэл, цогц байдлаар үзүүлэхээр зохион байгуулагдан ажиллана.

7.3.Хавдрын өвөрмөц эмчилгээний клиник

Хавдрын өвөрмөц эмчилгээний клиникт хорт хавдрын туяа, хими, сэргээн засах тусламж, үйлчилгээний тасаг хамаарч тухайн чиглэлээр улсын хэмжээнд төрөлжсөн мэргэшлийн лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

7.4.Хавдрын яаралтай тусламжийн клиник

Хавдрын яаралтай тусламжийн клиникт мэдээгүйжүүлэг, өвдөлт намдаах тасаг, яаралтай тусламжийн тасаг, эрчимт эмчилгээний тасаг, хөнгөвчлөх эмчилгээ, сургалт арга зүйн тасаг, ангиографийн тасаг, дурангийн тасгууд хамаарна. Хавдрын яаралтай тусламжийн клиник нь тухайн чиглэлийн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг нэгдмэл, цогц байдлаар үзүүлэхээр зохион байгуулагдан ажиллана.

7.5.Дүрс оношилгооны тасаг

Бүх байрлалын хорт хавдрын рентген, хэт авиа, компьютерт томограф, уян дурангийн оношилгоо, эмчилгээг хийж, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэх үйлчилгээг үзүүлж, шаардлагатай дүрс оношилгооны дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлнэ.

7.6.Лабораторийн тасаг

Хорт хавдрын эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээнд шаардлагатай лабораторийн шинжилгээг хийж, онош баталгаажуулах эмчилгээний үр дүнг хянахад шаардлагатай нотолгоо, дүгнэлтийг гаргана. Молекул генетикийн лабораторийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй цогц байдлаар үзүүлж, эрдэм шинжилгээ судалгааны ажил хийнэ.

7.7.Эмгэг судлалын тасаг

Амьд ахуйн эд, эсийн сорьцонд шинжилгээ хийж эмгэг өөрчлөлтийг эд, эсийн түвшинд оношилно. Амьд ахуйн эд, эс сорьцын оношилгоог олон улсын ангилал, нэршил, зэрэглэлийн дагуу тогтоох, хавдрын эрт үеийн илрүүлэлт, сургалт, эрдэм шинжилгээний ажилд оролцон хамтран ажиллана.

7.8.Сувилахуйн алба

Төвийн хэмжээнд сувилахуйн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр, стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулан арга зүйгээр хангаж ажиллана.

7.9.Эм зүйн алба

Эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, эмч мэргэжилтнийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

7.10.Эдийн засаг, төлөвлөлт, гадаад харилцааны алба

Төвийн хөгжлийн дунд хугацааны болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хяналт шинжилгээ хийх, гадаад хамтын ажиллагааны гэрээ хэлцэл хийх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. Төвийн тусламж, үйлчилгээний өртөг зардлыг тооцох, эдийн засгийн дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулах, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг тодорхойлно. Төвийн үйл ажиллагааны статистик мэдээ, мэдээллийг бүртгэх, мэдээллэх, тайлагнах, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.11.Нийгмийн эрүүл мэнд, сургалт, мэдээллийн алба

Төвийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөр, бодлогын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулж, бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг судлах, урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх зөвлөмж боловсруулах, энэ чиглэлээр бусад салбар, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана. Хавдрын төрөлжсөн мэргэшлийн чиглэлээр төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж, хавдрын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

7.12.Хүний нөөц, хөгжлийн алба

Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөлтийг хийх, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, мэдлэг, мэргэжлийг тасралтгүй дээшлүүлж, ажлын байран дахь сургалтыг зохион байгуулна.

7.13.Санхүү бүртгэлийн алба

Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, эрүүл мэндийн даатгал, санхүү, эд хөрөнгийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ. Хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх санхүүгийн аудитыг зохион байгуулна.

7.14.Бүртгэл тандалт, эрт илрүүлгийн алба

Үндэсний түвшинд хүн амд суурилсан хорт хавдрын өвчлөлийн бүртгэл, шалтгаан, тархалтыг судалж, тандалт судалгааны чиглэлээр бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, улсын хэмжээний эрт илрүүлгийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулна.

7.15.Мэдээллийн технологийн алба

Төвийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн мэргэжлийн зөвлөгөө, сургалт явуулахад шаардлагатай техникийн нөхцөлөөр хангах мэдээллийн технологийн үйл ажиллагааг зохион байгуулна.

7.16. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба

Эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийх, засвар үйлчилгээтэй холбогдолтой мэдээллийн сан байгуулж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

7.17.Хангамж, үйлчилгээ, аж ахуйн алба

Төвийн барилга, цахилгаан, ус, дулаан хангамж, эд хогшил, эмнэлгийн цэвэрлэгээ үйлчилгээ, автомашины хэвийн үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, бүрэн бүтэн байдлыг хариуцаж, харуул хамгаалалт, аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна. Байгууллагын гадаад болон дотоод орчны тохижилтыг хийж, үйлчилгээний соёлыг сайжруулан ажиллана.

7.18.Халдварын хяналт, сэргийлэлтийн алба

Халдварын хяналт, сэргийлэлт, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулна.

7.19.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний алба

Хэвтэн эмчлүүлэгчид болон тус төвөөр үйлчлүүлэгчид, ажиллагсдад эмчилгээний болон зөв зохистой хоолоор мэргэжлийн түвшинд тэгш, хүртээмжтэй, тасралтгүй үйлчилгээг зохион байгуулна. Мөн элэг шилжүүлэн суулгах хагалгааны үеийн битүүмжилсэн эмчилгээний хоол, үйлдвэрлэл үйлчилгээний стандартыг бий болгож, нутагшуулан нэвтрүүлнэ.

Найм. Бусад зүйл

8.1.Энэхүү дүрэмд тусгагдсанаас бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

--oOo--

Хоёр. Төвийн үндсэн зорилго, түүний эрх, үүрэг

2.1.Төвийн эрхэм зорилго хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч байхад оршино.

2.2.Төвийн зорилго нь Монгол улсын хүн амыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношилох, эмчлэх, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, зөвлөх, гүйцэтгэлийг хянах, тайлагнахад оршино.

2.3.Төвийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь хавдартай тэмцэх ажлыг өмчийн хэлбэрээс үл хамааран эрүүл мэндийн бүх шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, нийт хүн амын нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан явуулахад оршино.

2.4.Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.4.1.Үйлчлүүлэгчийг дээдлэх,

2.4.2.Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах,

2.4.3.Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих,

2.4.4.Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах,

2.4.5.Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах,

2.4.6.Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах,

2.4.7.Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах,

2.4.8.Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх.

2.5.Төвийн эрх

2.5.1.Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэл зүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

2.5.2.Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, материаллаг болон хүний нөөц, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах,

2.5.3.Ижил чиг үүрэг бүхий гадаадын эмнэлэг, төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн хавдрын тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох,

2.5.4.Судалгаа, шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах,